



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/447

Эрдэнэт

Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 /а/, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори болон үндсэн үйл ажиллагааг Төрийн үйлчилгээний нэгдсэн байранд нүүлгэн шилжүүлэх болсонтой холбогдуулан лабораторийн тоног төхөөрөмж, бусад эд хогшлыг нүүлгэн шилжүүлэх, тоног төхөөрөмжүүдийг ажиллуулахад шаардлагатай цахилгааны шугам, дотоод сүлжээ татах, тоног төхөөрөмжүүдийг суурилуулах, иргэдэд үйлчлэх танхимыг тоноглоход шаардагдах 18.000.000 /арван найман сая/ төгрөгийн зардлыг хавсралтаар баталсугай.

2.Энэхүү зардлыг Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 04 дүгээр тогтоолоор батлагдсан Эрдэнэт сангийн зардлын жагсаалтад тусгагдсан “Барилгын материалын сорилт шинжилгээний лабораторийн тоног төхөөрөмжийг нүүлгэн шилжүүлэх, баталгаажуулах, суурилуулах зардал”-аас санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



С.БАТЖАРГАЛ



Аймгийн Засаг даргын 2017 оны  
07 дугаар сарын 25-ны өдрийн  
442 дугаар захирамжийн хавсралт

### ЗАРДЛЫН ТОВЧОО

№	Зардлын нэр	Шаардагдах хөрөнгө /мян.₮/
1	Дотоод сүлжээ татах, сервер байрлуулан тоноглох	2.865.00
2	Цахилгааны шугам татах, дагалдах холболт, тоноглол хийх зардал	2.900.00
3	Үйлчилгээний танхимыг тохижуулах, хаалт хийх зардал	5.298.00
4	Цонхны хамгаалалтын тор, хаалга, хяналтын камер суурилуулах зардал	1.370.00
5	Лабораторийн тоног төхөөрөмж суурилуулах, баталгаажуулах, лабораторийн байрыг зориулалтын дагуу тоноглох зардал	4.577.00
6	Шилэн кабель шилжүүлэх зардал	990.00
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>18'000.00</b>

\_000\_